



КЪРВИРАТ

ДРАНИШ
КАДЪКА

Франц Кафка

Хувирал

Нэгэн өглөө Грегор Замза сэрвэл орон дотроо хачин муухай шавж болон хувирчээ. Нуруундаа хуягтай болж, гэдэс нь эрчлээтэж нумрах бөгөөд өндийж харвал хөнжил нь бондойсон бор гэдсэн дээрээс нь хариугүй гулсах нь ээ. Биетэй нь харьцуулбал жигтэйхэн чөргөр хөлнүүд нь ийш тийш сарвалзана.

Зүүд биш байгаа даа, “Би яачих нь энэ вэ?” хэмээн бодоод өрөөгөө ажвал арай жижигхэн болчихсон гэмээр санагдсанаас өөр өөрчлөгдсөн юмгүй. Эсэн бусын даавууны үлгэрүүд тавьсан ширээний дээхнэ талд зурагтай сэтгүүлээс саяхан шиг хайчилж аваад алтан шаргал хүрээнд хийж өлгөсөн хөрөг зураг харагдана. Замза гүйдэг менежерийн ажилтай байлаа. Хөрөг зурган дээр үстэй малгай өмсөж, нөмрөг нөмөрсөн нэгэн хатагтай гараа томоо гээчийн үстэй углуурганд шургуулаад урагш сунгажээ.

Грегор цонхоор харвал тавцан дээр нь бороон дуслууд тог тог хийн дусалж, тэнгэр бүрхэг байх нь сэтгэлээр улам унагав. “Жаахан дуг хийгээд энэ тухай мартаж юм сан” гэж бодсон ч баруун талаараа унтаж сурсан болохоор ийм байдалтай эргэх боломжгүй болжээ. Баруун тийшээ эргэсэн ч буцаад л гэдэргээ харчихаад болж өгсөнгүй. Бараг зуунтаа эргэх гэж оролдоод сарвалзсан хөлнүүдээ харахгүйн тулд нүдээ анивал хавирган тушаа нь урьд хожид байгаагүйгээр өвдөхийг мэдэрлээ.

“Бурхан минь, ямар ч төвөгтэй ажил сонгочих нь энэ вэ? Өдөр болгон ийш тийшээ явна. Дэлгүүрт суухтай харьцуулахад санаа зовох зүйл хамаагүй их. Замдаа ядарч зүдрэхийн зэрэгцээ байнга л галт тэрэгний цагийн хуваарь бодож, олигтой хоол ундгүй явахаас гадна үй олон хүнтэй түр зуурын танилын холбоо тогтооно. Ёстой чөтгөр аваасай.” Гэдэс нь загатнаж, толгойгоороо орны толгой түшээд өндийвөл гэдсэн дээр нь жижигхэн цагаан цэгнүүд байх юм. Гэдсээ хөлөөрөө маажих гээд дагжис хийн чичирлээ.

Грегор буцаж хэвтээд “Ингэж хар үүрээр сэрээд байвал галзуурч ч мэднэ. Хүн гэдэг амьтан хангалттай нойр авах хэрэгтэй. Авсан захиалгаа тэмдэглэх гэж зочид буудалдаа буцаж ирж байхад бусад гүйдэг менежерүүд дөнгөж л цайлж суудаг шүү дээ. Намайг тэгвэл эзэн маань тэр дор нь хөөнө дөө. Гэхдээ хөөгдсөн нь дээр ч юм уу, хэн мэдэх вэ. Эцэг эхийнхээ нэр нүүрийг бодоогүй бол аль хэдийнэ эзэндээ юү бодлогоо ний нуугүй хэлээд ажлаасаа гарчих байлаа. Хэлэх үгийг минь сонсоод тэр лав хөл дээрээ тогтохгүй дээ. Лангуун дээр суугаад ажилчидтайгаа ярих дуртай мөртлөө чих султай болохоор ажилчид лангуунд наалдах шахуу зогсох хэрэг гарна. Эцэг эхийнхээ тавьсан өрийг төлчих мөнгө цуглуулчихвал ч тэр дороо л гарна даа. Гэхдээ тэр болтол бас тав зургаан жил байна аа. Галт тэрэг маань таван цагт хөдлөх болохоор босохоос доо” гэх уйтай бодолд дарагдав.

Авдран дээр дуугарах сэрүүлгээ харвал зургаа гуч өнгөрчээ. “Бурхан минь, сэрүүлэг дуугарсангүй дээ.” Орон дээрээс харвал сэрүүлгээ яг дөрвөн цагт дуугарахаар тааруулж. Модон авдар дээр жингэнэн дуугарах сэрүүлгээ сонссонгүй гэж үү? Грегор эсэн бусын зүүд зүүдэлсэн ч нам унтжээ. Долоон цагаас дараагийн галт тэрэг хөдлөх учраас шалавлахгүй бол горьгүй ээ. Гэсэн ч даавуунуудынхаа үлгэрийг боож баглаагүйн дээр хөнгөн шингэн босоод явчих тэнхээ алга. Энэ галт тэргэнд амжлаа ч компанийх нь худалдааны төлөөлөгч таван цагийн галт тэргийг тоссон болохоор

эзэндээ банга авахуулах нь мэдээж. Төлөөлөгч ааш муутай бөгөөд эзний талын хүн. Өвдсөн гэвэл ажилдаа ороод таван жил болоход ганц ч удаа өвдөөгүй түүнийг хардаж сэрдэнэ. Эзэн энэ дэлхийн хүн болгоныг эв эрүүл сав саруул, гагцхүү ажиллах дургүй байдаг хэмээн хэлэх дуртай эмчээ дуудаж, Грегорыг залхуу хэмээн эцэг эхийнх нь чихнээс хонх уях нь баараггүй. Энэ удаад тэр эмчийн түмэн зөв болох нь ч гарцаагүй. Ингэж бодоод Грегор нойр нь л ханаагүйгээс биш бие нь хөнгөн шингэн бөгөөд жигтэйхэн өлссөнөө мэдлээ.

Элдвийг бодож хэвтэх зуур аль хэдийнэ зургаа дөчин тав болж, хэн нэгэн хаалга зөөлхөн тогшлоо.

-Грегор, зургаа дөчин тав болж байна шүү дээ. Явах болоогүй юм уу? гэх ээжийнх нь дуу сонсогдоно.

Грегор хариу хэлэхдээ өөрийнхөө дууг таньсангүй. Урьдынхтайгаа адил боловч хирдхийлгэм хачин жигтэй шуухитнах шиг болов. Тэрээр чухам яагаад байгаагаа тайлбарлах гэж оролдсон ч арга буюу:

-За ээж ээ, одоо бослоо гэхээс өөр юм хэлсэнгүй.

Хаалганы цаанаас ээж нь хүүгийнхээ дуу хоолойг өөрчлөгдсөнийг анзаарсангүй, шүр шар хийн явж одлоо. Гэсэн ч гэрийнхэн нь Грегорыг хоцорсон хэдий ч гэртээ байсаар байгаад гайхширч, төдхөнөө аав нь хаалга нүдэх нь тэр.

-Грегор, Грегор! Чи чинь яачихсан юм бэ? гээд арай аядуухнаар хэд хэд дуудав.

Хажуугийн хаалганы цаанаас дүү нь:

-Грегор, бие чинь зүгээр үү? Би туслах уу? хэмээнэ.

Грегор аль болох аядуу тайвнаар “Би зүгээр дээ” гэхэд аав нь цайгаа уухаар явсан ч дүү нь аанай л:

-Грегор, онгойлго л доо гэсээр үлдлээ.

Гэсэн ч Грегор хаалгаа онгойлгосонгүй. Энд тэнд томилолтоор явсаар байгаад шөнөдөө хаалгаа түгжиж сурсандаа битүүхэн баярлана.

Тэрээр орондоо ингэж хэвтээд байвал санаанд нь олигтой юм орж ирэхгүйг мэдээд яаралгүй босч, хувцсаа өмсөөд өглөөний цайгаа уунгаа яах ийхээ бодохоор шийдлээ. Өөөдчихсэн нуруу нь босонгуут зүгээр болчих шиг санагдана. Грегор гүйдэг менежерүүдийн мэргэжлийн өвчин гэж болох ханиад хүрч хоолой нь сөөж дээ хэмээн бодлоо.

Гэдсээ нэг төмбийлгөхөд л хөнжил нь гулсаад уначихав. Босох гэсэн ч бие нь өргөөшөөгөө суначихсан ч юм шиг.

Гараа тулаад босох гэвэл хоёр гарныхаа оронд ийш тийш сарвалзах хэд хэдэн хос хөлтэй болчихсон байх юм. Нэг хөлөө нугалах гэвэл өнөө хөл нь тэнийх бөгөөд арай ядан нугалбал бусад хөл нь ёстой л хэдэн тийшээ сарваганана. Грегор “Орондоо ингэж шал дэмий хэвтэхгүй юм шүү” хэмээн өөрөө өөртөө хэллээ.

Цээжнийхээ доод хэсгээр гулсаж буухаар оролдвол биеийнх нь энэ хэсэг бараг л хөдөлдөггүй гэж хэлж болохоор юм. Грегорын уур нь хүрч огцом хөдлөөд биеэрээ орны төмөр цохиж тэсэхүйе бэрх өвдлөө.

Цээжнийхээ дээд хэсгээр буух гэж толгойгоо орны зах руу чиглүүлбэл цээжин бие нь хөлбөрч, толгой нь орноос унжив. Толгойндоо дийлдээд унаж бэртэх вий гэхээс айж ухаан алдсан дорвол орондоо хэвтээд үлдсэн нь дээр санагдана.

Үй олон удаа оролдож оролдож толгойгоо чүү чамай орон дээр гаргахад хөлнүүд нь хэдэн тийш сарвалзаж, юутай ч орноосоо босохгүй л бол бүтэхгүй нь гэдгээ ойлгов. Грегор тэвдэж сандарснаас айвуу тайвуу бодож тунгаах нь хавьгүй үр өгөөжтэй гэдгийг санан байж тайвшрахын тулд цонхоор харахад манан бууж, нарийн гудмын цаад талд юу байгаа нь харагдахаа больжээ. Сэрүүлэг дахин дуугарахад тэрээр “Долоон цаг болж байхад манан арилдаггүй” хэмээн бодоод хэдэн хором тайван амьсгалж, нам гүм байвал бүх юм эргээд байрандаа орж магадгүй хэмээн хүлээлээ.

Грегор “Дэлгүүр долоон цагаас өмнө онгойдог болохоор ямартаа ч долоо дөчин таваас өмнө босохгүй бол намайг сурж хүн явуулах нь мэдээж” хэмээн өөрөө өөртөө хэллээ. Цээжин биеэ тэр чигт нь холбируулж орноосоо босох гэж оролдвол толгойгоороо унаснаас арай дээр. Нуруу нь их л хатуу санагдсан учраас хивсэн дээр унахад гэмтэхгүй нь лавтай. Дуу шуутай унах нь гарцаагүй тул гэрийнхэн айдаггүй юмаа гэхэд санаа зовох нь мэдээж. Гэсэн ч босохоос өөр арга алга даа.

Тал биеэрээ орноос унжаад, энэ бүхэн бүхий л биеэрээ хоёр тийш савлах зугаатай тоглоом мэт санагдаж, хэн нэгэн тусалбал хялбархаан босчихно гэдгээ ухаарлаа. Аав, гэрийн үйлчлэгч хоёр түүнийг татаж босгоод газарт тавьж эргүүлэхэд энэ хэдэн сарвалзсан хөлийг нэг ашиглахтайгаа болно доо. Гэлээ гээд хаалга түгжээгүй байсан ч Грегор хэн нэгнийг дуудна гэж үү? хэмээн бодоод зовлонтой нөхцөл байдлаа түр ч атугай умартан тэсэлгүй инээлээ.

Грегор хүчтэй савласнаас болоод тэнцвэрээ бараг алдан унах дөхвөл хэн нэгэн хонх цохих нь сонсогдлоо. “Пүүсээс хүн явуулж дээ” гэж бодвол хэдэн хөл нь улам сарваганав. Хэсэг хугацаанд нам жим байх зуур Грегор “Үүдээ нээхгүй нь дээ” хэмээн хий дэмий найдсан ч төд удалгүй үйлчлэгч хаалга онгойлгох нь дуулдаж, ирсэн гийчний мэнд мэдэхийг сонсоод Грегор чухам хэн болохыг нь мэдлээ. Пүүсийн зохион байгуулагч өөрийн биеэр иржээ. Грегорын пүүсийн ажилчид үл ялиг алдаа гаргамагц л хатуу шийтгүүлнэ. Үнэндээ бүх ажилчид нь яахаа алдчихсан гэмт этгээдүүд гэж үү? Өглөөний хэдэн цаг ажлаа цалгардуулснаас болж зохион байгуулагч энэ бүхнийг ямар ч гэм зэмгүй гэрийнхэнд нь дуулгахаар өөрийн биеэр ирэх учиртай гэж үү? Хэн нэгнийг явуулж асуулгах шаардлагатай бол дагалдангаа явуулчихаж болох л байсан. Тэгэвч зохион байгуулагч энэ хэргийг түүнээс өөр хүн шийдчих чадваргүй хэмээн үзэж өөрөө ирж л дээ. Грегор сандарсандаа орноосоо пид хийн уналаа. Хивсэн дээр унасан тул учиргүй их түжигнээгүй ч нилээн дуу шуу гарав. Нуруу нь Грегорын бодсоноос арай уян хатан байж. Унахдаа толгойгоороо газар мөргөж, өвдсөндөө хивсэнд шилгээлээ. Зүүн талын өрөөнөөс:

-Тэнд нэг юм уначих шиг боллоо доо гэх зохион байгуулагчийн дуу гарна.

Грегор өөрт нь тохиолдсон шиг хачин жигтэй явдал зохион байгуулагчид тохиолдсон байж магад гэж төсөөлөхийг оролдоход мань эр хажуугийн өрөөнд локан гутлаараа шар шар хийлгэн хэд хэд алхалж, энэ бодлыг нь замхрууллаа. Баруун талын өрөөнөөс дүү нь:

-Грегор, зохион байгуулагч ирчихсэн байна шүү дээ хэмээн шивнэнэ. Грегор:

-Мэдэж байна аа гэсэн ч дүүдээ дуулдахаар чанга хэлж чадсангүй. Энэ үед аав нь зүүн талын өрөөнөөс:

-Грегор, пүүсийн зохион байгуулагч ноёнтон ирлээ. Өглөөний галт тэргээр яагаад яваагүйг чинь асууж байна. Юу хэлэхээ мэдэхгүй юм. Чамтай уулзмаар байна гэх юм. Хаалгаа нээ. Өрөө чинь ямар байх нь хамаагүй шүү дээ гэлээ. Энэ үед зохион байгуулагч:

-Өглөөний мэнд, ноён Замза хэмээв.

-Өвдсөн юм шиг байна аа, ноёнтоон. Грегор галт тэрэгнээс хоцрох ёсгүй л дээ. Хүү маань ажлаасаа өөр юм ямар бодох биш. Оройдоо ч гэрээсээ цухуйхгүй. Ирснээсээ хойш найм хоног гэртээ л байлаа. Сонин уншаад, эс бөгөөс галт тэрэгний хуваарь хараад л суух юм. Хааяахан модоор элдэв зүйл хийхээс өөр юм сонирхохгүй. Саяхан шиг хийсэн сайхан жаазыг Та өрөөнд нь ороод харна аа. Та харин хүрээд ирсэн нь болж. Грегор зөрүүдлээд хаалгаа онгойлгодоггүй. Бидэнд хэлээгүй ч бие нь тавгүйрхсэн байх хэмээн ээж нь ярьлаа. Энэ хооронд аав нь үүдэнд зогсоод байсан бололтой.

Грегор тэдний яриаг нэгд нэгэнгүй сонсох гэсэндээ аядуухнаар:

-Би одоо гарлаа гэлээ.

-Би ч тэгж бодсон л доо. Гэхдээ бие нь гайгүй байлгүй дээ. Харамсалтай нь, худалдаа наймааны салбарт ажилладаг бид чинь энэ биеэ үл хайхран ажлаа хөөцөлдөх үе гарах юм даа гэхэд аав нь тэвчээр алдан:

-Ноёнтон одоо өрөөнд чинь орж болох нь ээ дээ? гээд хаалгыг нь тогшиход Грегор:

-Болохгүй ээ гэвэл зүүн талын өрөөнд нам гүм болж харин баруун талын өрөөнд байх дүү нь мэгшиж эхлэв.

Дүү нь яагаад өрөөндөө суугаад байгаа юм бол? Дөнгөж босоод хувцаслаж амжаагүй байх л даа. Тэгээд юу болоод уйлчихав даа? Грегор өдий болтол босолгүй, зохион байгуулагчийг өрөөндөө оруулалгүй ажлаа ч алдаж мэдэхийн зэрэгцээ пүүсийн эзэн эцэг эхийг нь урьдын адил шаналгаж эхэлнэ гэж бодсоноос гарцаагүй. Гэсэн ч одоохондоо эмээхэд эрт байна аа. Грегор гэртээ байгаа бөгөөд гэр бүлийнхнийгээ хаяж явах бодолгүй байлаа. Хивсэн дээр хэвтэж байгаа ч тэд түүнийг чухам ямаршуу нөхцөл байдалтай байгааг мэдвэл зохион байгуулагчийг өрөөнд нь оруулах гэж зүтгэх нь юу л бол. Хожмоо эвтэйхэн тайлбарлачихаж болохоор иймэрхүү аар саархан зүйлээс болж Грегорыг халахгүй нь лав. Энэ үед тэд уйлж гувшихын оронд түүнийг тайван орхивол дээр юм шиг санагджээ. Гэвч гэрийнхэн нь үнэндээ энэ бүх нөхцөл байдлыг огт мэдэхгүй байснаас Грегорыг шалсаар байлаа.

-Юу болоо вэ, ноён Замза? Та өрөөгөө түгжээд чимээ ажиггүй, ажил үүргээ ч байж боломгүйгээр цалгардуулах юм. Эцэг эх, пүүсийн эзний нэрийн өмнөөс Танд гэж хэлэхэд энэ бүхнээ даруйхан тайлбарлаад өг. Би учрыг нь ер олохгүй юм. Таныг ухамсартай тайван залуу хэмээн эндүү ташаа бодож. Эзэн Танд саяхан өгсөн инкассогоос болоод ажилдаа ирсэнгүй гэж сэрдэж байсан ч би Таныг өмөөрөхөд бэлэн байсан шүү. Харин энэ байдлыг чинь хараад эргэлзэж эхлэх нь. Уг нь Тантай уулзъя гэж бодсон ч зөрүүд зангаас чинь болоод эцэг эхийн чинь хажууд хэлэхээс өөр аргагүй боллоо. Ойрын үед Таны ажил бүтэл муутай байгаа шүү дээ. Энэ үед

борлуулалт буурдаг ч гэлээ нэг ч атугай гэрээ байгуулаагүй нь хачирхалтай биш гэж үү?

Ингэж хэлэхдээ зохион байгуулагчийн дуу илт өндөрсөв. Грегор сандарсандаа бүхий л зүйлээ умартаж:

-Ноёнтоон, би одоохон хаалгаа онгойлголоо. Толгой эргээд босч чадахгүй байна л даа. Гэхдээ одоохон бослоо. Арай дээрдэж байна. Орой гайгүй байсан ч өглөө ингэнэ чинээ санасангүй. Та ээж, ааваас асуусан ч болно шүү. Өглөө бие дээрдэх байх гэж бодоод хэл хүргүүлсэнгүй л дээ. Ноёнтоон, эцэг эхийг маань бодооч дээ. Та миний сүүлд явуулсан захиалгануудыг үзэж амжаагүй байх л даа. Найман цагийн галт тэргээр явчихъя. Хэдэн цаг унтсан чинь дээрдэх шиг боллоо. Ноёнтоон, би шалавхан ажилдаа яваад очъё. Эзэнд ч ингэж дамжуулаад өгөөч гэлээ.

Грегор ингэж хэлэнгээ авдар түшин босох гэж оролдоно. Хаалгаа нээж, зохион байгуулагчтай уулзан, хэрхэн хувирч өөрчлөгдсөнөө харуулахыг хүсэв. Тэд түүнийг хараад айвал гэм буруугүй гэдгийг нь тэр дороо ойлгоно шүү дээ. Ингээд энэ нөхцөл байдлыг айвуу тайвнаар хүлээж авбал Грегор санаа зовох зүйлгүй найман цагийн галт тэргэнд суух нь мэдээж. Грегор авдраас бариад хэд хэд гулссан ч нуруугаа өвтгөсөөр босч чадлаа. Сандлын түшлэг налаад суудлаас нь хөлөөрөө чангаав. Удалгүй Грегор биеэ бүрэн захирч аваад зохион байгуулагчийн ярианд чих тавьлаа.

-Та нар хүүгээ юу хэлснийг нь ойлгов уу? Энэ хүн бид хэдээр тохуурхаад байгаа юм биш үү? гэхэд ээж нь:

-Бурхан минь, яалаа гэж дээ. Бие нь муу байхад бид зовоогоод байгаа ч юм бил үү. Грета, Грета хэмээн дуудахад хажуугийн өрөөнөөс дүү нь:

-Ээж ээ гэх нь сонсогдов.

-Грегор өвдсөн юм шиг байна. Эмчийнх рүү гүйгээд ир. Грегорын дууг сонсоо биз дээ?

-Амьтан шиг л дуугарсан шүү дээ хэмээн зохион байгуулагч аядуухан хэллээ. Энэ үед аав нь:

-Анна, бушуухан яваад засварчин дагуулаад ир гэлээ.

Төдхөн хоёр бүсгүй даашинзаа шүр шар хийлгэсээр гарч одох нь сонстов. Грегор дүүгээ хэдий завандаа хувцаслачихдаг байна аа хэмээн бодлоо. Хаалга хаагдах нь сонсогдоогүй бөгөөд гэрт ихээхэн гай зовлон тохиолдсон үед хаалгаа хаалгүй санд мэнд гарч явдаг шиг энэ удаад хаахаа мартсан бололтой.

Грегорын сэтгэл амарлаа. Гэрийнхэн нь түүний үг хэлийг ойлгохгүй байсан ч тэрээр аль хэдийнэ дуу хоолойдоо дасаад хэвэндээ байх шиг санагдана. Гэрийнхэн нь Грегорыг нэг л хэвийн бус байгааг мэдээд туслахаар сандралджээ. Иймээс ч эмч, засварчин хоёр ирэхэд бүх юм эргээд хэвэндээ орох байх хэмээн найдав. Нөхцөл байдлаа аль болох ойлгомжтой тайлбарлахын тулд хоолойгоо чимээгүйхэн зассан ч энэ дуу авиа нь хүнийх шиг сонсогдсон гэдэгт итгэж өгсөнгүй. Том өрөөнд нам жим болж аав, ээж нь зохион байгуулагчтай хамт ширээнд суугаад ярилцаж байсан ч юм бил үү, эс бөгөөс хаалганд нь чих тавин чагнаж байгаа ч юм бил үү, бүү мэд.

Грегор сандлаа түрэн хаалганд ойртож хөлөөрөө түшиж зогслоо. Хөлөнд нь ямар нэг

зууралдсан бодис наалджээ. Ингээд жаал амсхийгээд түлхүүрээ амаараа эргүүлэв. Шүдгүй боловч завьж нь хатуу юмаа. Төд удалгүй ам нь гэмтсэн бололтой бор өнгийн шингэн дусаллаа. Грегор түлхүүрээ чанга зуугаад завьжаа шалбалчихжээ. Энэ үед хажуу өрөөнөөс зохион байгуулагч:

-Түлхүүрээ эргүүлээд байх шиг байна шүү гэхэд Грегор баярласан ч “Грегор минь, жаахан хүчлээд эргүүл. Цоожоо мултла” хэмээн хашгирсан бол арай дээр байх байлаа. Тэд хөдөлгөөн бүрийг нь анаж буйг мэдээд Грегор түлхүүрээ хүчлэн эргүүлж, тэр аяараа хөлөөрөө товшино. Түлхүүр зуусан амаараа тэнцвэрээ олж байсан бөгөөд хаалганы цоож гэнэт тор хийн мултрахад “Засварчин ирэхээс өмнө онгойлгочихлоо доо” хэмээн сэтгэж, толгойгоороо бариулыг нь татаж хаалгаа нээлээ.

Грегор хаалгаа онгойлгоод унахгүйг хичээн, нөгөө өрөө рүү болгоомжтой явлаа. Энэ үед нөгөө өрөөний хаалган тушаа зогсох зохион байгуулагч түүнийг олж хараад амаа барьж, уулга алдан ухрав. Зочин ирсэн ч үс нь сэгсийсэн ээж нь аав руу нь нэг хараад Грегор руу хоёр алхаад ухаан алдав. Ээжийнх нь үс нүүр лүү нь унжжээ. Аав нь Грегорыг өрөө рүү нь буцаагаад түлхэж оруулахыг хүссэн бололтой гараа атгаж, эргэн тойрноо хараад нүүрээ даран енгэнэтэл уйллаа.

Үнэндээ Грегор том өрөөнд орж амжаагүй бөгөөд үүдээр нь л шагайсан байж. Гудамжны нөгөө талд жигдхэн цонхтой эмнэлгийн том саарал байшин харагдана. Бороо татарч хааяахан том том дуслууд дуслах юм. Өглөөний ундыг ихэд чухалчлан үзэх аав нь сонин хэвлэл уншингаа бараг цаг шахам цайлж суух учраас зочны өрөөний ширээ дүүрэн аяга таваг өрөөстэй. Эсрэг талын ханан дээр Грегорын цэрэгт алба хааж байсан үеийн зураг өлгөөстэй байх агаад дэслэгч цолтой байсан тэрээр сэлмэн дээрээ гараа тавиад малилзтал инээжээ. Үүдний хаалга онгорхой болохоор хонгилын шат харагдана.

-Би одоохон хувцаслаад үлгэр загваруудаа аваад гарлаа. Намайг явуулмаар байгаа биз дээ? Ноёнтоон, би ажилдаа дуртай шүү дээ. Томилолтоор яваад ядардаг ч явдал суудалдаа аль хэдийнэ дасчихсан. Ноёнтоон, Та хаачих нь вэ? Конторт очоод намайг хэлнэ биз дээ? Хүн гэдэг амьтан заримдаа ажиллах сонирхолгүй болдог ч урьдын амжилт бүтээлээ бодоод сэтгэл сэргэдэг. Би эзний өмнө хүлээсэн үүрэгтэй. Эцэг, эх, дүүгээ тэжээх хэрэгтэй гэдгийг Та мэднэ дээ. Би ийм болчихсон ч удахгүй зүгээр болно оо. Намайг ойлгож миний талд орно биз дээ. Хүмүүс гүйдэг менежерүүдэд дургүй л дээ. Цулайтлаа мөнгө олж, эрх дураараа амьдардаг гэж боддог шүү дээ. Гэхдээ Та эзнээс ч илүү энэ нөхцөл байдлыг мэднэ шүү дээ. Жилийн турш гадуур явдаг учраас элдвийн хэл аманд өртөж, нүдэн балай, чихэн дүлий явсаар өөрийгөө хамгаалах ямар ч боломжгүй байдаг. Гадуур явж явж ирээд энэ бүхнээ мэднэ. Ноёнтоон, жаахан хүлээгээч дээ. Намайг ойлгосон гэдгээ хэлээд өгөөч.

Зохион байгуулагч Грегорыг эргэж хараад үүд рүү ямар нэг хүчинд татагдах мэт удаан гэгч нь хөлөө зөөлөө. Хаалганд дөхөж очоод тэрээр хөлнийхөө улыг түлсэн мэт ухас хийн гарч одов. Ингээд шатан дээр амсхийх мэт алхаа нь удааширлаа.

Грегор ажлаа алдахгүйн тулд зохион байгуулагчийг энэ чигээр нь явуулчихаж болохгүй. Аав, ээж нь түүнийг энэ пүүсдээ насан туршдаа ажиллах юм шиг санаж, өдөр тутмын аахар шаахар зүйлсэд л санаа тавих болжээ. Грегор зохион

байгуулагчид нөхцөл байдлаа ойлгуулж, өөрийн талд оруулах хэрэгтэй гэдгээ мэдэж байлаа. Ингэж байж гэмээ нь тэднийх амь зуулгатайгаа үлдэнэ шүү дээ. Охин дүү нь байсан бол эмс хүүхнүүдэд бузгай дуртай зохион байгуулагч үгэнд нь орох л байсан. Дүү нь хаалгаа хаагаад зохион байгуулагчид энэ бүхнийг тайлбарлаж өгөх байсан ч гадагшаа гарсан тул Грегорт өөрөө өөртөө найдахаас өөр зам үлдсэнгүй. Грегор энэ биеэ яаж хөдөлгөхөө мэдэхгүй байсан бөгөөд хэл яриа нь ойлгомжгүй байгаа эсэхийг үл хайхран шатны бариулаас зуурсан зохион байгуулагч руу тэмүүлж, тэнцвэр алдан унав. Хөлөн дээрээ унасан учраас бие нь хөнгөрөх шиг болж, хаа дуртай газраа гүйж чадах болсноо мэдэрлээ. Энэ үед хажууд нь хэвтэх ээж нь гэнэт ухасхийн босоод гараа сарвайлган “Бурхан минь, туслаарай” хэмээн орилж, Грегорыг харах гэж тонгойсон ч өөрийн эрхгүй ухарч, ард нь тээглэсэн ширээн дээр суучихав. Ээж нь хивсэн дээр кофе асгарахыг ер анзаарсангүй. Грегор:

-Ээж ээ, ээж ээ гээд зохион байгуулагчийг түр мартан, асгарсан кофег хараад өөрийн эрхгүй хэд хэд ангалзлаа. Ээж нь энэ бүхнийг хараад орь дуу тавьсаар аавыг нь тэврээд авав. Энэ үед зохион байгуулагч сүүлчийн удаа эргэж хараад “Пөөх” хэмээн дуу алдаж, шат алгасан харайлган одлоо.

Зохион байгуулагч зугтсанд өдий болтол шазуур зуун тэвчээр зааж байсан аав нь сэтгэлээр нэг мөр унаж, түүний хойноос гүйхгүй юмаа гэхэд Грегорт саад болохгүй байхын оронд баруун гартаа зохион байгуулагчийн орхисон таягийг, зүүн гартаа том сонин барьсаар хоёр гараа савчин хөлөө дэвсэлж, Грегорыг өрөө рүү нь туулаа. Зохион байгуулагч зочны өрөөний сандал дээр пальто, бүрх малгай хоёроо орхиод арилжээ. Грегор эцгээ тайвшруулах гэсэн ч тэрээр юу ч ойлгосонгүй бололтой. Грегор толгойгоо хүлцэнгүй гэгч нь сэгсэрвэл эцэг нь хөлөө улам хүчтэй дэвсэлж, түүнийг хөөв. Гадаа хүйтэн байсан ч ээж нь цонхоо нээгээд, нүүрээ даран цааш харжээ. Хаалга цонхоор салхи нэвт үлээж, хөшиг дэрвэлзэн, сонин сэтгүүлүүд шүр шар хийнэ. Аав нь зэрлэг адгуус шиг муухай орилон Грегорыг туухад мань хүн аажуухан ухарлаа. Тэр дороо эргэчихвэл өрөөндөө орчих боловч эцгийгээ айлгахыг хүссэнгүй. Грегорыг хөлөө чирэн эргэх зуур эцэг нь нүүр нүдгүй балбаад алчихаж мэднэ. Ухрахдаа хаашаа явахаа мэдэхгүй байгаагаа ухаарсан Грегор түнтэгнэн эргэж эхлэхэд аав нь таягаараа чиглүүлнэ. Угтаа бол аав нь араатан шиг архираагүй сэн бол Грегор учраа олчих шиг санагдана. Өрөөнийхөө хаалганы өмнө ирвэл цээж нь хаалгаар багтаж орохооргүй өргөн юм. Аав нь хаалганы нөгөө хавтасыг нээж дотогш оруулахын оронд сандарч тэвдсэндээ ухаан мадаггүй хашгичив. Грегор босоод өрөөндөө хажуулдан орж болох ч аав нь хүлээж тэвчихгүй. Тиймээс ч түүнийг хаалгаараа багтаж орохгүйг нь анзааралгүй хашгичин туусаар байлаа. Грегорын араас дуулдах дуу чимээ аавынх нь дуу хоолой гэхэд итгэхэд бэрх ээ. Залуу айсандаа хаалгаар чихэж, босгон дээр нь хажуулдан хэвтэхэд биеийнх нь нэг тал зүсэгдсэн бололтой цагаан хаалган дээр хачин муухай толбо хүрэнгэнэ. Грегор хаалган завсар гацаж, нэг талын хөлнүүд нь сарваганаад, нөгөө хөлнүүд нь шаланд шахагдав. Энэ үед аав нь Грегорыг өшиглөвөл мань хүн өрөөндөө үсрэн орж, хаалга тас хийн хаагдаад чимээ аниргүй боллоо.

Грегор ухаан алдсан мэт нам унтаад сэрвэл хэдийнэ харуй бүрий болжээ. Чимээрхэж сэрээгүй ч нойр нь ханаж. Хэн нэгний хөлийн чимээ, үүдний өрөөний хаалга хаагдах дуунаар сэрсэн нь тэр. Хана, адраар гудамжны гэрэл тусах ч шалан дээр харанхуй. Грегор хөлөө торжигнуулан хаалганд ойртлоо. Цээжин бие нь зүүн талаараа зүсэгдэж, өглөөний явдлаас болоод нэг хөл нь хөдөлгөөнгүй болоод чирэгдэх аж.

Үүд хавиас хоол үнэртэж, хэдэн зүсэм талх дүрсэн сүүтэй таваг харагдлаа. Өглөөнөөс хойш өлссөн Грегор баярласандаа толгойгоо тэр чигт нь сүүнд дүрэв. Гэвч төдхөнөө л идэхээ болилоо. Зүүн тал нь өвдөхийн сацуу дүүгийнх нь тавьсан сүү дуртай сүү шиг нь амттай байсангүй. Грегор эргээд өрөөнийхөө гол руу мөлхлөө.

Цоожны нүхээрээ харвал зочны өрөөний гэрэл асаалттай байх агаад оройдоо аав нь ээж, дүү хоёрт дүнгэнэтэл сонин уншиж өгдөг бол энэ өдөр нам жим байх ажээ. Дүү нь захиандаа энэ тухай бичдэг байсан боловч аав нь сүүлийн үед сонин уншиж өгөхөө больчихсон ч юм бил үү хэмээн бодоод чих тавьбал гэрт амьд амьтан үлдээгүй мэт чимээ аниргүй. Грегор “Манайхан ч дуу шуугүй сууцгаах юм даа” гэж бодоод гэрийнхнийгээ ийм орон сууцанд амьдрах боломжтой болгосондоо хөөрнө. Энэ амар амгалан аж амьдрал нь ингээд дуусвал яана даа хэмээх уйтай бодлоо үлдэн хөөж, өрөөгөөрөө мөлхөж эхэллээ.

Хажуугийн хоёр хаалга нэг нэг чахарч дуугараад буцаад хаагдчихав. Хэн нэгэн өрөөнд орох гэсэн ч эмээсэн бололтой. Грегор хэнийг нь мэдэх гэж зочны өрөөний хаалган тушаа манаж зогссон ч хаалга дахиж онгойсонгүй. Өглөө хүн бүр л өрөөнд нь орохын түүс болж байсан бол хаалгаа онгойлгосных нь дараа хэн ч шагайхыг хүссэнгүй. Хоёр хаалганд гаднаас нь түлхүүр зоожээ.

Ингээд үдэш болоход зочны өрөөний гэрэл унтарч аав, ээж, дүү гурав нь өрөө рүүгээ өлмий дээрээ гишгэлэн орох нь тэр. Өглөө болтол Грегорын өрөөнд хэн ч орж ирэхгүй нь тодорхой болж, энэ бүхнийг тунгааж бодох зай гарлаа. Грегор энэ өрөөндөө таван жил амьдарсан ч өдгөө өрөө нь их л өндөр мэт санагдана. Айсандаа буйдангийн доогуур мөлхөж орсон ч цээжин бие нь хэтэрхий өргөн тул бүхлээрээ багтсангүй. Буйдан хэтэрхий намхан болохоор цээжин дээрээс нь дарах юм.

Шөнөжингөө буйдан дор хэвтэж, өлссөндөө сэрвэлзээд, юун түрүүнд тайван байж гэрийнхнийгээ айлгалгүй энэ нөхцөл байдалд тайвшруулах хэрэгтэй дээ.

Үүрээр дүү нь хувцсаа өмчихөөд зочны өрөө рүү орох хаалгыг нь нээж харцаараа Грегорыг хайн буйдан дор байхыг нь олж хараад цочсондоо хаалгаа тас хийн хаав. Ах нь нисч чадахгүйгээс хойш өрөөнийхөө хаа нэгтээ байх нь тодорхой шүү дээ. Гэсэн ч хэдэн хормын дараа дүү нь гэмшсэн бололтой үүдээ нээгээд хүнд өвчтөний өрөөнд, эс бөгөөс гадны хүний өрөөнд орох мэт болгоомжтой нь аргагүй өлмий дээрээ гишгэлсээр дөхөж ирлээ. Грегор буйдан дороос толгойгоо цухуйлгаад дүүгээ ажиглав. Сүүгээ уугаагүйг нь анзаарах болов уу? Өөр аятайхан идэх юм авчрах болов уу? хэмээн бодож буйдан дороос гарахыг хүссэн ч дүү нь хоол авчраагүй аваас гарч ирж айлгаснаас энэ чигтээ өлсөж үхсэн нь дээр хэмээн үзлээ. Тавагтай сүү нь бага зэрэг цалгисан ч хэвээрээ байхыг хараад тавгийг нь алчуураар жийрэглэж бариад гарч одов. Грегор дүү нь юу авчрах бол хэмээн толгой гашилгана.

Төд удалгүй дүү нь хуучин сонин дээр янз бүрийн амттан шимтгэн тавиад орж ирлээ. Сонин дээр муудсан ногоо, соусанд дүрсэн яс, бага зэрэг үзэм, Грегорын хоёр өдрийн өмнө голоод орхисон жаахан бяслаг, хатсан талх, цөцгий түрхээд дээрээс нь давс цацсан талх зэргийг тавьжээ. Үүнээс гадна аль хэдийнэ Грегорын идүүр болгосон бололтой нөгөө тавгандаа ус хийгээд ирэв. Дүү нь энэ бүхнээ тавьчихаад түүнд саад болохгүй гэсэн шиг тэр дороо гарч, хаалгаа тор хийн цоожиллоо. Хоол унд харсан Грегор шаламгай гэгч нь хөдлөв. Шарх нь эдгэрсэн бололтой. Сар гаруйн өмнө хуруугаа зүссэн нь уржигдар хүртэл хөндүүртэй байсныг санасан Грегор “Өвчнөө мэдрэхээ больж байгаа юм байх даа” гэж бодоод бяслаг үмхлээ. Яагаад ч юм бэ эхлээд бяслаг идмээр санагджээ. Ингээд ногоогоо идэж дуусгаад шинэхэн хоол хүнс түүнд огт таалагдахгүй байгааг анзаарав. Грегор идэх юмаа хэсэг хэсгээр нь хэмэлж аваад зөөлөө. Идэж дуусаад хэвтвэл дүү нь түлхүүр эргүүлэх нь сонсогдож цатгалдаад бараг унтаж байсан Грегор цочин сэрж буйдан доогуур орлоо. Цадаад буйдан доогуур бараг багтахаа больжээ. Дүү нь идсэн хоолных нь үлдэгдэл, Грегорын ам хүрээгүй хоол ундыг хэдийнэ хэрэггүй болсон мэт шүүрдэж аваад хогийн саванд хийж тосгуураар таглаад авч гарав. Дүүгээ цааш хармагц Грегор буйдан дороос гарч ирээд суниах шиг боллоо.

Үүнээс хойш Грегор өдөр бүр энэ маягаар хооллох болов. Дүү нь өглөөгүүр аав, ээж, үйлчлэгч гурвыг сэрэхээс өмнө, үд өнгөрмөгц тэр хоёрыг дуг хийж, үйлчлэгч гарах хойгуур хоол авчирна. Эцэг эх нь Грегорыг өлсгөж алахыг хүсээгүй ч хүүгээ хэрхэн хооллодгийг мэдвэл улам сэтгэлээр унана хэмээн сэтгэж л дээ.

Тэр өглөө эмч, засварчин хоёрт юу хэлж гаргасныг Грегор мэдсэнгүй. Хэн ч Грегорын үг хэлийг ойлгохгүй байх агаад харин тэрээр бүгдийг нэгд нэгэнгүй ойлгож буйг улс амьтан мэдсэнгүй. Дүү нь орж ирэх тоолондоо залбирах бөгөөд аажимдаа ахынхаа энэ байдалд дасчээ. Хааяахан Грегор авчирсан зүйлийг нь тэр чигт нь идвэл “Хоол нь таалагдсан бололтой. Бүгдийг нь идчихэж” гэнэ. Тэгэвч ихэнхдээ “Дахиад л хоолоо үлдээчихэж” хэмээнэ.

Хажуугийн өрөөнд дуу шуу гарвал Грегор хаалгандаа наалдана. Эхэн үед байнга л өөрийнх нь тухай ярих бөгөөд гэрийнхэн нь хооллохоор суухдаа түүнтэй хэрхэн харьцах талаар хэлэлцэнэ. Хэн ч гэртээ ганцаараа үлдэхээ больжээ. Үйлчлэгч чухам юу мэдсэн нь тодорхой бус байсан ч эхний өдөр ээжийнх нь өмнө өвдөг сөхрөн ажлаасаа чөлөөлж өгөхийг гуйгаад арван таван минутын дараа нулимс дуслуулан талархаж, чингэж гуйгаагүй ч энэ нөхцөл байдлын тухай хэнд ч ам алдахгүй хэмээн өчих юм.

Ээж, дүү хоёр нь хоолоо хийх болсон ч гэрийнхэн нь барагтаа бол юм идэхээ больжээ. Гурван биенээ юм идэхийг ятгах агаад “Одоо цадчихлаа. Идмээргүй байна” гэх үгс дуулдана. Гэрийнхэн нь юм уухаа ч больсон бололтой. Дүү нь аавдаа шар айраг авчирч өгье гэсэн ч аав нь хариу хэлсэнгүй. Грета үүдний манаачийг шар айрганд явуулъя гэвэл аав нь эрс татгалзаж, энэ тухай дахиж ам ангайсангүй.

Эхний өдөр Грегорын аав ээж, дүү хоёрт нь үүссэн нөхцөл байдлыг тайлбарлаж хэлээд таван жилийн өмнө дампуурсан пүүсээс нь үлдсэн цорын ганц эд хогшил болох кассын хайрцагнаас тэмдэглэлийн дэвтэр, ямар нэгэн баримт гаргаж ирэв. Энэ

үед Грегорт кассын хайрцагны түлхүүр эргүүлж, цаас шүр шар хийх нь дуулдана. Аавынхаа яриаг сонсоод Грегор дампуурсан пүүсээс нь юу ч үлдээгүй хэмээн эндүү бодож байснаа ухаарлаа. Аваасаа мөнгө төгрөгний талаар асуудаггүй байсан бөгөөд тэднийг нэг мөр итгэл найдваргүй болгосон энэ явдлыг аль болох хурдан мартаасай хэмээн хүсч байв. Тиймээс ч Грегор ажилдаа махруу зүтгэж, ойр зуурын юманд зарагддаг байснаа гүйдэг менежер болтлоо суга дэвшсэн гэхэд хилсдэхгүй. Гүйдэг менежерийн цалин хамаагүй их, олсон захиалгынхаа тодорхой хувийг бэлэн мөнгөөр шан харамж болгон авна. Энэ мөнгөө гэртээ авчрахад гэрийнхэн нь баярласандаа хэлэх үгээ олж ядан амаа ангайдаг сан. Грегор гэр бүлээ жинхэнэ утгаар нь муугүй тэжээчихдэг байлаа. Гэрийнхэн нь ч Грегорын өгсөн мөнгийг авч сурчээ. Грегор ч гэрийнхнээсээ мөнгөө харамлаж явсангүй. Гэсэн ч анх мөнгө олоход нь баярлаж хөөрсөн шиг халуун дулаан хүлээж авахаа аандаа больсон юм. Дүү нь л Грегортой урьдын адил дотночилж, хийл тоглодог дүүгээ төлбөр ихтэй ч дараа жилээс хөгжмийн сургуульд оруулах нууцхан хүсэлтэй болж билээ. Гэртээ байхдаа Грегор хөгжмийн сургуулийн талаар хааяахан ам нээх ч эцэг эх нь дургүйцнэ. Энэ тухайгаа дорвитой ярьж байгаагүй ч дотроо нилээд няхуур бодож, Зул сарын өмнө тэдэнд хэлэхээр шийджээ.

Грегор хаалганд чих тавин наалдахдаа энэ мэтчилэн эсэн бусын юм бодож зогссоор байгаад ядарвал толгойгоороо хаалгаа мөргөчихдөг байлаа. Энэ үед гэрийнхэн нь хаалга тог хийхийг сонсоод “Бас юу болоод байна даа?” гэсэн шиг дуугаа хураацгаана. Ингээд аав нь Грегорын өрөөний хаалга руу хэсэг хараад яриагаа үргэлжлүүлнэ.

Энэ маягаар Грегор тэдэнд бага ч гэсэн мөнгөн хадгаламж үлдсэн хийгээд (ээж нь нэг удаа ярихад барагтаа ойлгохгүй учраас аав нь дахин дахин тайлбарлана) энэ нь хэдэн жилийн хүүтэйгээ бага зэрэг өссөнийг мэдэж авав. Үүнээс гадна тэд Грегорын сар бүр өгөх мөнгөний тодорхой хэсгийг хадгалдаг байжээ. Цалингаасаа хэдхэн гульден л авч үлддэг байж. Хаалга налан зогсохдоо энэ бүхнийг дуулсан Грегор толгой дохин гэрийнхнийгээ арвич хямгач байгаад нь баярлана. Грегор энэ мөнгөөр аавынхаа зээлийн тодорхой хэсгийг дарж пүүсээс гарах тэр өдрөө ойртуулж болох ч аав нь мөнгөө хадгалж байсанд хязгааргүй баярлажээ.

Гэсэн ч хадгаламжийнхаа хүүгээр амьдрахад арай л хүрэлцэхгүй, сайндаа л нэг, хоёр жилийн амин зуулга аж. Энэ нь дураараа үрэх бус хүндхэн цаг үе ирэхэд хэрэглэх мөнгө байлаа. Иймээс амь зуухын тулд ажиллах хэрэгтэй. Аав нь бие сайтай ч хэдийнэ хөгширч, сүүлийн таван жил гэртээ сууснаас болоод босож суухдаа удаан болжээ. Гэртээ ч байнга амьсгаадах багтраа өвчтэй, нас дээр гарсан ээж нь ажил хийж чадахгүй. Ээж нь бараг өдөр бүр амьсгаадаж цонхон тушаа орон дээр хэвтээ харагддаг. Арван долоо хүрсэн ч хар нялхаараа дүү нь мөнгө олж чадна гэж үү? Эрх танхил дүү нь урьдын адил үд болтол унтаж, гоёж гоодон, гэрийнхээ ажилд тусалж, гадуур жаахан зугаацаж явахаас гадна хамгийн гол нь хийл хөгжмөө тоглох хэрэгтэй. Амь зуух мөнгө хэрхэн олох тухай ярьж эхлэхэд Грегор ичиж зовсондоо халуу шатаж, хаалганы хажуугийн арьсан буйдан дээр тэрийн унана.

Грегорын нойр хулжиж, шөнөжингөө сэрүүн хэвтэх бөгөөд сандлаа цонх руу түлхээд дээр нь гарч цонхоор харна. Энэ үед Грегор өөрийгөө эрх чөлөөтэй болсон мэт санадаг байлаа. Өдрөөс өдөрт Грегорын хараа муудаж, урьд нь харсаар байгаад

залхсан эмнэлгийн барилга бараг үзэгдэхээ болив. Нам гүмхэн ч хотын төвийн Шарлоттенштрасс гудамжинд байрлах гэрийнх нь эргэн тойрон элсэн цөлд байгаа мэт чимээ аниргүй. Дүү нь сандал цонхны хажууд байхыг хоёр удаа хараад өрөөг нь цэвэрлэх тоолондоо сандлыг нь тэнд үлдээж, цонхны дотор талын хавтасыг нээлтгэй орхих болжээ.

Грегор дүүдээ хичнээн их талархаж буйгаа хэлж чаддаг сан бол сэтгэл нь амрах байж.

Өдрөөс өдөрт ахыгаа илүүтэй халамжилж, санаа тавих ажээ. Өрөөнд нь орж ирүүтээ хаалгаа хаах гэж яаралгүй год үсрэн цонхоо нээж, жихүүн ч гэлээ ч хэдэн хором агаар амьсгалж зогсоно. Өдөрт хоёр удаа дүү нь орж ирээд цонх руу санд мэнд гүйхэд Грегор ихэд айх бөгөөд цонхоо хаалттай чигээр нь үлдээгээд нэг өрөөнд байвал сэтгэл нь амрах шиг санагдана.

Грегор хувирснаас хойш сарын дараа нэгэн өглөө цонх түшин зогсож байхад нь Грета орж ирлээ. Дүүд нь энэ байдал аймшигтай санагдсан бололтой дав хийн цочиж, хаалгаа хаагаад түгжив. Грегор дүүгээ цонхны дэргэд отож байгаад хазах гэсэн мэт хөндлөнгөөс харагдсан байх л даа. Дүүгээ хараад буйдан доогуур орсон ч Грета үд болтол орж ирсэнгүй. Ингээд дүү нь түүнийг ийм байдалтай харж чадахгүйгээс гадна буйдангаас цухуйх хэсгийг нь хүртэл хэзээ ч тайван харж чадахгүй гэдгийг Грегор ойлгов. Иймээс дүүгээ айлгахгүй гэсэнлээ дөрвөн цаг ноцолдож байж орны бүтээлгээ буйдан дээр тохож, бүхлээрээ доогуур нь шургадаг боллоо. Дүү нь хүсвэл бүтээлгийг авч болох ч янзаар нь үлдээжээ. Грегор дурандаа энэ бүтээлгийг нөмөрсөнгүй. Бүтээлгэн дороос цухуйвал дүү нь харин ч баярласан шинжтэй.

Грегорын аав, ээж эхний хоёр долоо хоног өрөөгөөр нь огт үзэгдсэнгүй. Урьд нь охиндоо байнга уурладаг байсан бол эдүгээ магтаж сайшаах нь ихэсчээ. Аав, ээж нь Грегорын өрөөний үүдэнд охиноо гарч ирэхийг хүлээх агаад өрөө нь ямаршуухан байгаа, юу идсэн, яаж өөрчлөгдсөн зэргийг нь нэг нэгэнгүй лавлана. Ээж нь хүүгийнхээ өрөөнд орохыг хүссэн ч аав, дүү хоёр нь элдвийн шалтаг зааж ер ойртуулсангүй. Эхэн үедээ Грегор битүүхэндээ энэ бүхнийг дэмжиж байсан ч ээж нь сүүлдээ “Хүүгээ хармаар байнашүү дээ. Хөөрхий муу хүү минь” хэмээн орилж хашгирах болсонд ороод ирвэл сайхан болох шиг санагдлаа. Ээж нь энэ бүх нөхцөл байдлыг дүүгээс нь илүүтэй ойлгоно доо. Дүү нь хүүхдийн гэнэн томоогүй зантайдаа ч тэр үү, ахынхаа өрөөг цэвэрлэж үйлчлэх хүндхэн үүрэгтэй болжээ.

Төдхөнөө Грегорын ээжийгээ харах гэсэн хүсэл биеллээ. Эцэг эхээ бодоод өдрийн цагаар цонхоор харахаа больж, улмаар цаг үргэлж шалан дээгүүр мөлхөхөөс залхаад хоол унднаас ч таашаал авах нь багасав. Ингээд хана, таазан дээгүүр мөлхдөг болж, таазан дээрээс доошоо унжих дуртай болжээ. Доош унжихад чөлөөтэй амьсгалж болох агаад ийш тийш савлан мансуурч, заримдаа шалан дээр пид хийн унана. Грегор хувирч өөрчлөгдсөн биеэ бүрэн захирч сураад таазнаас унасан ч гэмтэхээргүй болжээ. Дүү нь ахыгаа шинэ сонирхолтой болсныг мэдээд өрөөнөөс нь авдар, бичгийн ширээ хоёрыг гаргав. Грегор мөлхсөн газраа наалдамхай бодистой мөр үлдээнэ.

Дүү нь ганцаараа энэ эд хогшлыг гаргаж чадахгүй учраас хэн нэгнийг дуудах хэрэгтэй болжээ. Аавыгаа дуудаж зүрхэлсэнгүй. Саявтархан ажилд авсан арван зургаатай тогооч охин гал тогооныхоо өрөөг түгжээд тогтсон тогшилтоор л онгойлгох учраас аавыгаа эзгүйчлэн ээжийгээ дуудлаа. Ээж нь хүүгээ харах болсондоо учиргүй баярлаж, уулга алдсан ч өрөөнийх нь үүдэнд ирээд дуугаа хураачихав. Дүү нь эхлээд Грегорын өрөөг шалгаад ээжийгээ оруулбал Грегор бүтээлгээ өөр лүүгээ татаж нуугдлаа. Бүтээлгэн дороос цухуйж зүрхэлсэнгүй. Ээж нь орж ирсэнд үнэхээр баярлажээ.

-Ах харагдахгүй байгаа. Ороод ир гэсээр дүү нь ээжийгээ хөтлөнө.

Туниа муутай эмэгтэйчүүд хуучин хүнд авдрыг арай ядан хөдөлгөх агаад Грета хамаг хүчээ шавхаж буй нь илт. Ээж нь болгоомжтой өргө гэсэн ч Грета үгэнд нь орохгүй зүтгэнэ. Арван таван минут ноцолдоод ээж нь аавыг нь ирэхээс өмнө амжихгүй болохоор энэ авдрыг байранд нь үлдээе гээд авдраа өрөөний голд авчирчихвал Грегорын замд садаа болохын нэмэр гэлээ. Тэгээд ч эд хогшлыг нь гаргачихвал Грегорт таалагдахгүй байж магад гээд хоосон хана харах ямар олиг байхав, өрөөг нь хоосолчихвол сэтгэлээр унах нь мэдээж хэмээнэ. Хүүгээ хаа байгааг нь мэдэхгүйн зэрэгцээ Грегорыг өөрийнхөө хэл яриаг ойлгохгүй гэдэгт бат итгэсэн ээж нь бараг шивнэх шахам:

-Хогшлыг нь гаргачихвал нөхцөл байдал нэгэнт сайнаар эргэхээсээ өнгөрсөн, хүүгээ ингээд хаячихлаа гэж бодох ч юм бил үү. Грегорыг буцаад хувиртал өрөөг нь энэ чигт нь үлдээсэн дээр байхаа даа. Тэгвэл энэ хар дарсан зүүдээ хурдан мартаж магад гэлээ.

Энэ яриаг сонсоод Грегор дөрвөн хананд түгжигдэн хаашаа ч гаралгүй байсаар ухаан санаа нь самуурч хэмээн бодлоо. Эс бөгөөс тэр чухам юуны учир хоосон өрөөнд үлдэхийг ингэж их хүсэмжлэх билээ дээ? Эрүүл саруул хүн өв залгамжилж авсан тавилгаа тавьж, аятайхан тохижуулсан өрөөгөө хаа сайгүй мөлхөж болох хоосон агуй болгохыг хүснэ гэж үү? Ингэвэл нүд ирмэхийн зуур хүн төрлөө мартаж нь тодорхой. Грегор ээжийнхээ дууг сонсоод ийн бодож тавилга сэлтээ энэ чигт нь үлдээвэл байдал сайжирч магад хэмээн эргэцүүлээ. Энэ бүх тавилга мөлхөхөд нь садаа болж, оюун бодлоо хадгалж үлдэхэд ихээхэн тустай.

Гэсэн ч дүү нь ахынхаа байдлыг гэрийнхнээсээ хол илүү гадарлах хүний хувиар өөртөө итгэлтэй нь аргагүй буйдангаас бусад эд хогшлыг гаргах хэрэгтэй хэмээн зөрүүдлэнэ. Грета ахдаа мөлхөх зай хэрэгтэйг мэдэх учир ингэж бодож л дээ. Грегорыг хувирснаас хойш охин дүү нь өөртөө машид итгэлтэй болжээ. Тэгээд ч Грегорт одоо тавилга огт хэрэггүй болсон гэв. Грета хүнд яаж ийгээд туслах санаа бодлоор дүүрэн байдаг тэр л насандаа яваа, ингэж сэтгэх нь ч гарцаагүй. Тиймээс ч Грегорт туслах гэсэндээ байдлыг улам хүндрүүлчих талтай. Хоосон өрөөний хаалгыг Гретагаас өөр хүн онголзуулах нь юу л бол.

Чингээд охин ээжийнхээ үгэнд оролгүй авдраа түлхэж эхэллээ. Ээж нь арга буюу хамжина. Грегор авдаргүй байж болох ч бичгийн ширээгээ авч үлдэх хэрэгтэй гэж бодоод тэр хоёрыг авдраа түлхсээр гармагц ээж, дүү хоёрынхоо ярианд эвтэйхэн оролцохоор буйдан дороос цухуйв. Харамсалтай нь ээж нь түрүүлж орж ирсэн

бөгөөд Грета хажуугийн өрөөнд өнөөх авдраа түлхсээр үлджээ. Ээж нь хүүгээ олигтой харж амжаагүй болохоор гэнэт харвал өвдчихөж ч магадгүй гэж бодсондоо Грегор буйдан доогуураа шургалвал бүтээлэг нь хөдлөв. Үүнийг анзаарсан ээж нь хэсэгтээ л чимээгүй зогсож байгаад гарч одлоо.

Грегор тавилга зөөхөөс өөр сүйдтэй зүйл болоогүй гэж бодох ч ээж, дүү хоёр нь эд хогшлоо түр тар хийн зөөх нь нилээн том өөрчлөлт болох шиг санагдаад, бүх биеэрээ шаланд наалдан өрөөг нь суллах энэ дуу чимээг сонсож чадахгүйгээ мэдэрлээ. Багаж хэрэгслүүдээ хийсэн авдрыг нь гаргаад, худалдааны коллежид байхдаа хичээлээ давтдаг байсан бичгийн ширээг нь түлхэж эхлэх нь тэр шүү. Хоёр эмэгтэй сайн санаалсандаа ингэж буйд ерөөс итгэж өгсөнгүй.

Тэр хоёрыг хажуугийн өрөөнд амс хийх зуур Грегор буйдан дороос гарч ирээд өрөөнийхөө чухам юуг хамгаалж үлдэхээ мэдэлгүй ийш тийш гүйгээд, хананд өлгөсөн хөрөг зурган дээр мөлхөж очлоо. Грегорын гэдэс жаазны шилтэй шүргэлцэж сэрүү татна. Зочны өрөө рүү эргэж харвал ээж, дүү хоёр нь ирж байлаа.

Грета ядарч сульдсан ээжийгээ сугаджээ. Дүү нь:

-Одоо юу гаргах вэ? гэж хэлэнгээ гэнэт Грегорыг олж хараад сандарсандаа ээжийгээ өрөөнөөс гаргахаар: -Ээж ээ, алив том өрөөнд нэг ороодохье гэх ажээ.

Грета ээжийгээ холдуулаад Грегорыг хананаас хөөж буулгах нь мэдээж. Харин Грегор Гретагийн нүүрийг маажихдаа тулсан ч хөрөг зургаа өгөхгүй дээ.

Ээж нь хажуу тийш нэг гишгэж, ханан дээрх нэлийсэн бор толбыг олж хараад балмагдаж цочсондоо “Бурхан минь!” гэсээр уулга алдаж, буйдан дээр ухаан алдан уналаа. Грета:

-Хүүе, Грегор! хэмээн гараа зангидаж хашгираад том өрөөнөөс дусаалга авчрахаар гүйв. Хувирснаас нь хойш анх удаа өөрт нь хандаж хэлсэн үгс энэ байж.

Грегор ээждээ туслахыг хүссэн ч шилэнд наалдчихжээ. Ингээд арай гэж шалан дээр буугаад, дүүгийнхээ хойноос хажуу өрөө рүү гүйлээ. Дүү нь дусаалга хайж байгаад эргэж харвал ардаа зогсох Грегороос дав хийн цочоод шилтэй эмээ алдчихав. Эмний шил хагарч нэг хэлтэрхий нь Грегорын нүүрийг шалбалаад, биен дээр нь муухай үнэртэй шингэн асгарлаа. Грета хэд хэдэн эм бариад ээж рүүгээ гүйж очин хаалгаа хөлөөрөө хаачихав. Грегор ийн өөрөөс нь айж мэгдсэндээ үхлийн ирмэгт ирсэн ээжээсээ холджээ. Одоо өрөөндөө орсон ч дүү нь айгаад зугатаж гарах нь тодорхой. Грета ээжийнхээ хажууд байх учиртай болохоор Грегорт хүлээхээс өөр арга байсангүй. Гэмшсэндээ хана, адраар мөлхөж эхлэв. Удалгүй толгой нь эргэж том ширээн дээр пид хийн уналаа.

Грегор хэсэг зуур ширээн дээр хэвтвэл өрөөнд нам жим байх агаад гэнэт үүдний хонх дуугарав. Үйлчлэгч бүсгүй гал тогооныхоо өрөөг дотроосоо түгжсэн болохоор Гретагаас өөр хаалга онгойлгох хүнгүй. Аав нь эргэж ирсэн бололтой. Гретаг балмагдсан байхыг хараад аав нь:

-Юу болоо вэ? гэвэл:

-Ээж ухаан алдаад. Одоо зүгээр л дээ. Грегор өрөөнөөсөө гарчихсан гэх нь дуулдана.

-Би хэлсэн байх аа. Хэлээд байхад та хоёр үгэнд орохгүй.

Аав нь Гретаг ойлголгүй Грегорыг хүч хэрэглэсэн хэмээн боджээ. Иймээс энэ бүхнийг сонссон Грегор аавдаа нөхцөл байдлыг ойлгуулахын тулд өрөөнийхөө үүдэнд гүйж очоод хаалганд наалдаж, хөөж туулгүй хаалгыг нь онгойлгочихвол өрөөндөө орчих хүсэлтэй байгаагаа харуулахыг оролдлоо. Тэгэвч аав нь ойлгох сөхөөгүй байжээ. Грегорыг харангуутаа уурсан хашгирав. Хувирснаасаа хойш гэрийнхэн нь хэрхэн өөрчлөгдсөнийг мэдээгүй ч чухамдаа гараа далайлган дайрах энэ хүн түүний эцэг гэдэгт итгэж өгсөнгүй. Ийш тийш томилолтоор яваад ирэхэд ядарч тамирдсан аав нь сандлаасаа ч босох тэнхэлгүй гараа даллаж харагддаг сан.

Грегор хааяахан ээж, аав хоёртойгоо зугаалах ахуйд туниа муутай аав нь үргэлж хоцрох агаад зогсож байж юм хэлнэ. Харин өдгөө аав нь давхар эрүү сууж, алтан шаргал товчтой хөх өнгийн хүрэм өмсөөд, үсээ арагш нь самнажээ. Хар нүд нь сэргэлэн гэж жигтэйхэн. Малгайгаа буйдан руу шидээд, гараа халаасалж, Грегор өөд хилэнтэй нь аргагүй алхлав. Аав нь хөлөө өндөр өргөж гишгэлэхэд тавхай нь хачин том харагдана. Хувирснаас хойш аав нь ихээхэн хатуу хандах болсныг Грегор мэдэхтэйгээ. Иймээс ч аавыгаа зогсонгуут зогсож хөдлөнгүүт гүйсээр өрөөгөө хэд хэд тойров. Грегор хана, таазаар мөлхвөл аавыгаа доромжилсноор ялгаагүй гэж санаад шалаар мөлхөнө.

Аавыгаа нэг алхахад Грегор хэд хэд алхах бөгөөд амьсгал нь давхцаж яах учраа олохгүй гүйсээр л байлаа. Хана өөд мөлхөж болох ч энд тэндгүй хуучны хээ хуар, хурц ирмэгтэй тавилга тавиастай. Гэнэт Грегорын хажууд алим унаадахав. Төд удалгүй дахиад нэг алим унав. Аав нь зоогийн ширээн дээр тавьсан алимнуудыг шидэлжээ. Энд тэндгүй алим өнхөрч, нэг нь Грегорын нуруун дээр нь онож ойсон ч дараагийн алим нуруунд нь зоогдов. Грегор өвдсөндөө зугтахыг оролдсон ч шаланд наалдаад ухаан алдлаа. Өрөөнийх нь хаалга нээгдэж, дотуур цамцтай ээж нь орилсоор гарч ирээд банзалдаа түүртэн унаж, ааваас нь зуураад “Хүүгээ өршөө!” хэмээн гуйх юм. Грета ээжийгээ ухаан оруулах гээд хувцсыг нь нимгэлжээ.

Нуруунд нь алим зоогдсоноос хойш Грегор сар гаран мөлхөж чадсангүй. Энэ явдлын ачаар эцэг нь түүнийг гэр бүлийнхээ нэгэн гишүүн хэвээр байгааг ойлгох шиг болж, дайсантайгаа ана мана тэмцэлдэх мэт хүч үзэлгүй энэ байдлыг тэвчихээс өөр аргагүй гэдгийг ашгүй ухаарах шиг боллоо. Тэглээ гээд Грегорын нуруунд зоогдсон алимыг хэн ч салгаж авсангүй.

Өдгөө Грегор нэг булангаас нөгөөд хүрэх гэж хэдэн минут болох агаад хана, таазаар мөлхөх тухай саналтгүй болжээ. Гэсэн ч эл явдлаас хойш Грегорыг шагнаж урамшуулсан мэт зочны өрөөний хаалга оройдоо онгойж, манай хүн гэрийнхнийхээ яриа хөөрөөг сонсож ажиглах боломжтой боллоо. Харин зочны өрөөнөөс Грегор харагдахгүй ээ.

Эдүгээ тэднийхэн Грегорыг ажлаа дуусгаад зочид буудалд оронгоо дурсан санагалздаг лугаа халуун дулаан яриа хөөрөө өрнүүлэхээ нэгэнт больжээ. Оройн хоолны дараа аав нь сандалдаа дуг хийж, ээж, дүү хоёр нь чимээгүйхэн сууна. Ээж нь бөхийж суугаад даашинзны дэлгүүрт өгөх хатгамал хатгана. Дэлгүүрийн худалдагч болсон дүү нь франц хэл үзнэ. Грета хэзээ нэгэн цагт арай өөр ажилд орохыг хүсч байлаа. Хааяадаа аав нь сэрээд ээжийг нь харангаа “Өнөөдөр ямар удаан оёдог юм бэ дээ” хэмээгээд буцаж унтахад ээж, дүү хоёр нь өөд өөдөөсөө инээмсэглэх ажээ.

Аав нь гэртээ ч хүрмээ тайлахгүй тул халат нь өлгөөстэй хэвээрээ. Гэртээ дуг хийхдээ ч эзнийхээ дуунаар хэзээд ажлаа гүйцэтгэхэд бэлэн зэлэн. Ээж, дүү хоёр нь хичнээн арчилсан ч өдөржингөө тайлаагүй хувцас нь хэдийнэ өнгөө алджээ. Грегор орой болгон аавыгаа толботой боловч гялалзсан товчтой хүрмээ тайлалгүй сандал дээр унтахыг аждаг байлаа.

Үдэш болоход ээж аавыг нь орондоо ор хэмээн сэрээнэ. Аав нь өглөө зургаад ажилдаа явах учраас тухтай унтаж амрах хэрэгтэй шүү дээ. Ингээд ажил хийх болсноосоо хойш жигтэйхэн зөрүүд болсон аав нь хэд хэд дуудуулж байж орондоо орно доо. Ээж, дүү хоёр нь аавын ханцуйнаас татаж гуйж аргадах ч суган дороос нь татах хүртэл хөдлөхгүй байсаар энэ үед арга буюу нүдээ нээж “Амьдрал гэж энэ дээ. Хөгширсөн хойноо амрах хувьгүй юм даа” хэмээнэ. Хоёр эмэгтэй хийж байгаа зүйлээ хойш тавиад хөгшнийг оронд нь хэвтүүлдэг байлаа.

Хэн хүнгүй толгой өндийх завгүй ажиллах тул Грегорт санаа тавих завтай хүн байсангүй. Мөнгөө хэмнэж үйлчлэгч бүсгүйгээ ажлаас нь халаад, нэг биерхүү эмэгтэйг хэрэг болсон үедээ дуудаж ажиллуулах болов. Ээж нь хатгамал хатгаж гэрийн ажлаа амжуулах ч мөнгө аанай л хүрэлцэхгүй. Тиймээс охинтойгоо баяр ёслолын үеэр зүүдэг үнэт эдлэлээ зарж эхэлжээ. Орой хэр мөнгө олсноо ярихад л Грегор энэ тухай дуулдаг байлаа. Гэрийнхэн нь энэ том байрнаас нүүх санаатай ч түүнийг яаж зөөхөө мэдэхгүй байв. Грегорыг нүхлэсэн хайрцганд хийгээд зөөж болох ч тэд энэ хүнд нөхцөлд итгэл найдвараа алдсан байсанд л хамаг учир оршино. Энэ хорвоод ядүү зүдүү хүмүүс юу л хийж болно тэр болгоныг хийж байж. Аав нь банкны ажилтнуудад хоол зөөж, ээж нь дотуур хувцас оёх агаад дүү нь дэлгүүрт ажиллана. Аав унтсаны дараа ээж, дүү хоёр нь Грегорын өрөөний хаалгыг хаачихаад мэгшин уйлах нь олонтаа.

Грегор сэрвэгнэж, хаалга нээгдмэгц эргээд хүн биендээ хувиран, гэрээ өөд нь татах сан хэмээн мөрөөсч, пүүсийн эзэн, зохион байгуулагч, захиалгын менежерүүд, дагалдан ажилчид, тосгоны зочид буудлын хөөрхөн үйлчлэгч бүсгүй, удаан гэгч нь эргүүлсэн малгай худалддаг дэлгүүрийн касс бүсгүй гээд эсэн бусын хүн амьтныг дурсан санана. Өлсөхгүй ч хааяадаа өөрийг нь хэн ч хайхрахгүй байгаад бухимдаж, зооринд орж дуртай юмаа олж авахыг хүснэ. Дүү нь ажилдаа гарахаас өмнө өглөө, өдөртөө эсэн бусын хоол унд хөлөөрөө түлхэж оруулаад Грегорыг идсэн идээгүй маргааш нь шүүрдэж хаях болжээ. Грета орой болгон Грегорын өрөөг шалавхан цэвэрлэх ч өрөөнд нь энд тэндгүй толбо, тоос шороо, хог новш хөглөрөх аж.

Эхэн үедээ Грегор дүүгээ орж ирэхэд эмхлүүлэх гэсэн шиг тоос шороо ихтэй булан тохойд очдог байсан ч дүү нь огт анзаарахгүй. Грета хог хөглөрснийг харсан ч тэр чигт нь үлдээгээд, өөрөөл нэгэн цэвэрлэгээ хийхийг илтэд эсэргүүцдэг байлаа. Нэг удаа ээж нь Грегорын өрөөнд их цэвэрлэгээ хийнэ гээд баахан ус асгасанд Грегорын дургүй хүрчээ. Тэр орой Грета энэ бүхнийг мэдээд Грегорын өрөөний цэвэрлэгээг охиндоо даатгасангүй гэж гомдсондоо цурхиран уйлсанд аав, ээж хоёр нь учраа олохгүй сандралдлаа. Ээж нь аавыг унтлагын өрөө рүү оруулахыг оролдож, дүү нь ширээ балбан, Грегор энэ бүхнийг сонсож дуулсандаа бухимдаж байлаа.

Яваандаа Грета ажилдаа түүртэж, Грегорыг асрахаа больсонд үйлчлэгч эмэгтэй орлох болов. Тэдний үйлчлэгч болох бэлэвсэн авгай энэ насандаа юу эсийг үзэв гэсэн шиг л Грегороос сүйдтэй жийрхсэнгүй. Эмэгтэй анх Грегорын өрөөний хаалгыг санаандгүй онгойлгоод түүнийг олж харсан ч ерөөс сандарч тэвдсэнгүй. Үүнээс хойш өглөө, оройдоо өрөөгөөр нь шагайж, өөрт нь аятайхан санагдсан бололтой “Наашаа хүрээд ир дээ”, “Манай шавж хаагуур явж байна?” хэмээн дуудах болов. Грегор дуу өгөлгүй нам хэвтээд, элдвээр дуудуулж байхын оронд өрөөгөө цэвэрлүүлэхийг хүсэмжлэх ажээ. Хаврын бороо шаагьсан нэгэн өглөө үйлчлэгч эмэгтэй Грегорыг дуудвал дургүй нь хүрсэн Грегор эмэгтэй рүү аажуухан эргэлээ. Эмэгтэй айхын оронд сандал бариад амаа ангайсаар:

-Ойртохгүй юм биз дээ? гээд өнөө сандлаа буланд тавиад гарч одов.

Грегор барагтаа бол юм идэхээ больж, үмхсэн зүйлээ хэдэн цаг хүлхэж байгаад гаргаж хаяна. Өрөө нь өөрчлөгдсөнөөс болж юм идэх хүсэлгүй болчих шиг санагдсан ч үнэндээ тэр харин ч эсрэгээр өрөөнийхөө энэ байдалд хурдан дасчээ. Тэднийх нэг өрөөгөө түрээслүүлсэн учраас хэрэггүй эд хогшлоо Грегорын өрөөнд тавих болов. Өрөөг нь түрээсэлсэн сахалтай гурван эр өрөөндөө төдийгүй гал тогоонд эмх цэгцтэй байхыг шаардана. Тэд тавилгатайгаа ирсэн учраас тэднийх зарж ч болохгүй, хаяж ч болохгүй жигтэйхэн олон новштой болоотхов.

Элдвийн хог новш болоод үнсний сав, хогийн сав зэргийг Грегорын өрөөнд тавив. Үйлчлэгч эмэгтэй зарим нэг зүйлийг Грегорын өрөө рүү шидэхэд түүнд зөвхөн эмэгтэйн гар болоод шидсэн эд хогшил харагдах бөгөөд Грегор мөлхөх зайгүй болж арга буюу эдгээр зүйлийг ийш тийш нь түлхэнэ. Энэ маягаар хэдэн цагийн дараа Грегор ядарч сульдах ч ингэж цаг нөхцөөх нь зугаатай санагдах болжээ.

Түрээслэгчид хааяахан оройн хоолоо зочны өрөөнд зооглох үеэр Грегорын өрөөний хаалга хаалттай байх авч Грегор үүнд сэтгэлээ чилээсэнгүй. Хаалга онгорхой үест ч харанхуй буландаа хэвтэх нь олонтаа. Нэг удаа үйлчлэгч эмэгтэй Грегорын хаалгыг

хаасангүй. Түрээслэгчид харьж ирээд зочны өрөөний гэрэл асаагаад аав, ээж, Грегор гурвын суудаг газар сууцгаахад ээж нь таваг дүүрэн мах, дүү нь чанасан төмс барьсаар орж ирлээ. Хоол унднаас уур савсаж, өнөө гурвын голд суусан нэг нь болсон үгүйг нь шалгах гэсэн шиг өнөөх махнаас огтлов. Зоог мань эрийн санаанд хүрсэн бололтой. Ээж, дүү хоёр нь сэтгэл амран инээмсэглэнэ.

Грегорины аав, ээж, дүү гурав гал тогоондоо хооллох агаад аав нь орж ирж мэнд мэдвэл түрээслэгчид хариу мэндлэнэ. Гурван эр үг дуугүй хооллоход мах зажлах чимээ л сонсогдох аж. Нэгэнтээ Грегор “Жаахан өөр юм идчихмээр л байна. Хүмүүс ямар их иддэг юм бэ?” хэмээн бодов.

Энэ үдэш Грегорыг хувирснаас хойш анх удаа гал тогооны өрөөнөөс хийл хөгжим эгшиглэжээ. Түрээслэгчид хооллочихоод сонин гарчиглацгааж суунгаа хөгжим сонсоод, үүдэн хавьцаа өлмий дээрээ очиход аав нь чимээ сонссон бололтой:

-Хөгжим саад болоод байвал одоохон болиулчихъя гэхэд голд нь зогсох эр:

-Хаанаас даа. Авхай энд ирээд тогловол дээр юм болов уу? гэлээ.

-Бололгүй яахав!

Төд удалгүй аав нь ноотны тавиур, ээж нь нооттой дэвтэр, дүү нь хийлээ барьсаар зочны өрөөнд орж ирлээ. Дүү нь хийлээ хөглөх зуур урьд нь өрөөгөө түрээсэлж үзээгүй эцэг эх хоёр нь түрээслэгчдийг ихэд хүндлэн суусангүй. Аав нь хаалга түшээд, ээж нь булангийн сандал дээр суулаа.

Дүү нь тоглож эхлэхэд ээж, аав хоёр нь анхааралтай гэгч нь ажиглах агаад Грегор зочны өрөө рүү шагайчихав. Өнгөрсөн цагтаа хүн болгоныг ихэд халамжилж явсан Грегор хувирснаасаа хойш энэ чанараа бага багаар алджээ. Өрөө нь хог новш, тоос шороонд дарагдаад, Грегорины нуруун дээр тоос тогтож, элдвийн утас, шөрмөс, үс ноос унжина. Урьд нь өдөрт хэд хэдэн удаа хивсэн дээр хөрвөөж, хог шорооноосоо салах ч өдгөө энэ бүхнийг тоохоо больжээ. Бохир заваан ч гэлээ зочны өрөөний гялалзсан шалан дээр явахаас эмээсэнгүй.

Хэн ч түүнийг анзаарсангүй. Өнөө гурав байн байн ноот руу өнгийж, дүүд нь садаа болох ч удалгүй холдож, цонхоор харж зогслоо. Мань гурав сайхан аялгуу сонсоно хэмээн эндүү бодсон бололтой уйтгарласан ч эелдэг загнаж хэл үггүй тамхиа татав. Үнэндээ дүү нь хачин сайхан тоглох юм. Грета толгойгоо гилжийлгээд ноотоо харна. Грегор дүүтэйгээ харц тулгарах гэсэндээ бага зэрэг урагшлав. Хөгжмийн аялгуу өчүүхэн нэг хорхой шавжийн сэтгэлийг ийн хөвсөлзүүлж чадна гэж үү? Амталж үзээгүй хоол хүнсэнд тэмүүлэх мэт дүүдээ дөхөж очоод хормойноос нь татаж өрөөндөө оруулахыг машид хүсэв. Хэн ч дүүгийнх нь тоглосон аязыг Грегор шиг үнэлж бишрэхгүй ээ.

Дүүгээ өрөөнөөсөө гаргалгүй өрөөл бусад орохыг завдвал хачин муухай дүр төрхөөрөө айлгамаар санагджээ. Гэхдээ дүүгээ хүчээр бус өөрийнх нь хүслээр өрөөндөө байлгахыг хүсэв. Гретаг хажууд нь суугаад толгойгоороо налахад хөгжмийн сургуульд оруулах санаатайгаа хэлж, шавж болон хувираагүй сэн бол хэн бугай ч эсэргүүцсэн бай өнгөрсөн Зул сарын баяраар энэ тухай дуулгах байснаа хэлнэ дээ. Зул сарын баяр өнгөрчихсөн биз дээ? Энэ тухай сонсоод дүү нь мэдээж уйлна. Харин энэ үед Грегор дүүгээ хүзүүн дээр нь үнсэх байсан.

Грегорыг ийнхүү бодолд автах үест өнөө гурвын нэг:

-Ноён Замза хэмээн өндөр дуугаар хэлээд дунд хуруугаараа өрөөний голоор удаан гэгч нь мөлхөх Грегорыг заав. Хөгжим тасалдаж, өнөөх эр нөгөө хоёр луугаа инээвхийлээд Грегорыг ширтэв. Аав нь хүүгээ хөөхөөс урьтаад өнөө гурвыг тайвшруулахыг оролдсон ч мань гурав огт сандарсангүй. Грегор тэдний хувьд хөгжим сонсохоос хавьгүй зугаатай болтой. Аав нь Грегорыг хааж зогсвол өнөө гурав аавд нь дургүйцсэндээ, эс бөгөөс ийм хөрштэй байснаа мэдээгүйдээ бухимдаж эхэллээ. Учир явдлыг тайлбарлахыг шаардсан ч өрөө рүүгээ орцгоов. Дүү нь сандарсандаа ноотоо гөлрөн хэдэн хором үг дүүгүй зогсоод, хийлээ ээждээ өгч өнөө гурвын өрөөнд гүйж ороод орыг нь засч эхэллээ. Грета түрээслэгч гурвыг өрөөндөө орохоос өмнө ор хөнжийг нь засчихав. Аавынх нь зөрүүд зан хөдөлж, өнөө гурвыг өрөө рүү нь хөөхөд үүдэн дээр тэдний нэгэн чанга дэвсэлж:

-Танайд ямар ч эмх замбараагүй учраас энэ өрөөг түрээслэхээ болилоо гээд нулимав. Бид энд байсан хэд хоногийн мөнгөө төлөхгүй. Энэ явдлын тухайд зохих газарт нь гомдол мэдүүлж ч магадгүй гэвэл нөгөө хоёр нь дуу дуугаа авалцан:

-Бид хоёр ч түрээслэхээ болилоо хэмээв.

Өнөөх эр хаалгаа тас хийн хаалаа.

Аав нь сандал дээрээ лаг хийн суугаад доош харахад Грегор өрөөнд байсаар, хүсэл мөрөөдөл нь биелээгүйд, өлсөж ундаассандаа тамирдан хөдөлж ч чадахааргүй болжээ. Гэрийнхэн нь хэзээ мөдгүй ундууцаж дайрах нь мэдээж. Ээж нь барьж байсан хийлээ алдахад Грегор цочсонгүй. Энэ үед Грета тэдний анхаарлыг татахын тулд ширээ тогшоод:

-Аав, ээж минь, ингэж амьдрах арга алга. Та хоёр ойлгохгүй байгаа ч гэсэн би ойлгож байна. Энэ муухай амьтны дэргэд ахынхаа нэрийг дурсмааргүй байна. Бид энэ амьтныг асарч халамжилж, чадах бүхнээ хийж, өдий болтол тэсч тэвчиж ирлээ. Тиймээс одоо энэ амьтнаас салах хэрэгтэй гэлээ. Аав нь үүнийг сонсоод:

-Гретагийн хэлдэг зөв өө гэхэд ээж нь нүдээ дүрлийлгэн гараа амаараа дараад ханиалгаж эхлэв.

Дүү нь ээжийнхээ толгойг түшихэд аав нь шийдсэн бололтой нуруугаа тэнийлгээд аяга таваг өрөөстэй ширээн дээр тавьсан малгайгаа эргүүлэн Грегорыг ширтэнэ. Ээж нь ханиалгаад ярих сөхөөгүй байсанд Грета аавдаа:

-Энэ амьтнаас ангижрах хэрэгтэй. Та хоёрыг алж ч мэднэ шүү. Өдөржин сунаж унатлаа ажиллаж ажиллаж гэртээ ирээд ийм юм тэвчих үнэхээр хэцүү байна. Би ч тэсэхгүй нь гээд ихэр татан уйлвал нулимс нь ээжийнх нь нүүрэн дээр дусална. Аргаа барсан аав нь:

-Охин минь, бид яалтай ч билээ дээ гэхэд дүү нь учраа олохгүй мөрөө хавчина.

-Энэ гэж амьтан хэл яриа ойлгодог бол ч...

Дүү нь уйлавч аавынхаа хэлснийг сонсоод ойлгохгүй нь мэдээж гэсэн шиг гараа савлаа.

-Хэл яриа ойлгодог бол тохирч болох сон. Даанч ...

-Эндээс далд орвол таарна. Аав аа, Та энэ амьтныг Грегор гэж бодсоны хэрэггүй. Бид хэд өдий болтол энэ амьтныг Грегор гэж бодож байснаас л ийм юм боллоо. Хэрэв зээ энэ Грегор мөн л юм бол амьд хүн ийм амьтантай хамт амьдрах аргагүй гэдгийг ойлгоод өөрөө яваад өгчих байсан юм. Ахгүй болсон ч сэтгэлдээ санан дурсах юмтай үлдэнэ дээ. Гэтэл энэ амьтан биднийг мөрдөж, түрээслэгчдийг хөөхөөс гадна энэ байрыг тэр чигт нь эзэгнэх санаатай юм шиг байна. Аав аа, хар даа. Дахиад л эхэллээ.

Дүү нь айсандаа Грегороос холдохын түүс болж, ээжээсээ холдон аавдаа дөхлөө. Аав нь охиноо тэвэрч авав.

Харин Грегор хэнийг ч, тэр тусмаа дүүгээ айлгахыг хүссэнгүй. Өрөөндөө орохоор арай ядан эргэхдээ толгойгоороо газар шилгээжээ. Грегор зогсоод гэрийнхэн рүүгээ эргэж харвал өнөө гурав санааг нь ойлгосон бололтой айхаа болиод уйтайхан харцаар ширтэв. Ээж нь ядарсандаа сандал дээр бараг хэвтээд нүдээ аньжээ. Дүү нь аавынхаа хүзүүгээр тэврээд суух юм.

Грегор “Одоо эргээд явж болох байх аа” гэж бодоод амьсгаадан хөдөлбөл хэн ч саад болсонгүй. Өрөө хүртэл нилээд зайтай тул сульдаж тамирдсан Грегор хэдэн мөчийн өмнө хэний ч хараанд өртөлгүй энэ хүрсэндээ гайхав. Өрөөндөө хурдхан орохын түүс болж гэрийнхэн нь дуугаа хураасныг анзаарах сөхөөгүй мөлхлөө. Үүдэн дээр эргэж харвал дүү нь босоод, ээж нь унтчихжээ.

Грегорыг өрөөндөө ормогц хаалгыг нь түгжлээ. Өрөөндөө явж ормогц л дүү нь “Ашгүй нэг орлоо” гээд шалавхан гүйж ирээд тор хийтэл түгжсэн нь энэ байж.

Грегор “Одоо тэгээд яавал дээр вэ” хэмээн өөрөө өөрөөсөө асуугаад, хөдөлж чадахгүй болсноо мэдлээ. Ингэлээ гээд балмагдсангүй. Харин ч өдий болтол чөрийсөн хөлөөрөө мөлхөж байсандаа гайхна. Хамаг бие нь өвдөх ч аажимдаа намдах шиг. Нуруунд нь зоогдсон алим хэдийнэ муудаад, тоос шороонд дарагдаж мэдрэгдэхээ больжээ. Грегор гэрийнхнээ хайрлан дурсана. Тэр дүүгээсээ ч илүүтэй алга болохыг хүсч байлаа. Ингэж бодсоор шөнийн гурван цаг болов. Үүр цайхад Грегор амьсгаатай байсан ч төд удалгүй толгой нь бөхийж, сүүлчийн удаа амьсгаа авлаа.

Өглөө эрт үйлчлэгч эмэгтэй ирж, хаалга үүд савсаар тэр хэдийг сэрээж орхив. Эмэгтэй сурсан зангаараа Грегорын өрөөгөөр шагайгаад гоц гойд юм ажигласангүй. Грегорыг гомдсон царайлаад, хөдөлгөөнгүй хэвтэж байна даа хэмээн бодоод шүүрээ хүргэвэл хөдөлсөнгүй. Эмэгтэй гайхсандаа түүнийг хөлөөрөө түлхвэл аанай л хөдөлсөнгүй. Үйлчлэгч эмэгтэй нүдээ бүлтийлгээд уулга алдан унтлагын өрөөний хаалгыг нээж:

-Таминь ээ, энэ чинь амьсгал хураачихаж! хэмээн хашгирлаа.

Орон дээрээ сууж байсан эр, эм хоёр үйлчлэгч эмэгтэйгээс цочоод, хэдэн хормын дараа л чухам юу болсныг ухаарав. Ингээд ноён Замза бүтээлгээ нөмрөөд, хатагтай Замза унтлагын хувцастайгаа Грегорын өрөөнд орлоо. Энэ үед өрөөгөө түрээслүүлснээс хойш зочны өрөөнд унтах болсон Грета хэдийнэ хувцаслачихсан бололтой гарч ирэв. Хатагтай Замза өөрөө хараад мэдчих байсан ч үйлчлэгч эмэгтэйгээс:

-Үхчихсэн гэж үү? хэмээн асуухад эмэгтэй:

-Харин тийм ээ гээд Грегорын цогцсыг шүүрээрээ түлхэв. Хатагтай Замза шүүрийг нь холдуулах гэсэн ч хөдөлж зүрхэлсэнгүй. Ноён Замза:

-Бурхан тэнгэрт талархах хэрэгтэй болж дээ гээд залбирвал өнөө гурав нь дагах ажээ. Грета:

-Ямар их тураа вэ дээ? Аль эртнээс юм идээгүй болохоор арга ч үгүй биз дээ хэмээнэ.

Үнэндээ Грегорын бие хав хавтгай болжээ. Хөл нь биендээ наалджээ. Хатагтай Замза:

-Грета, наашаа ороод ир дээ гээд гунигтай инээмсэглэвэл Грета Грегорын цогцсыг харсаар аав, ээжийнхээ өрөөнд орлоо. Үйлчлэгч хаалгыг нь хаагаад цонхоо нээлээ. Өглөө эрт байсан ч гадаа дулаарчээ. Гурван сар шувтарч байлаа.

Энэ үед түрээслэгч гурав өрөөнөөсөө гарч ирээд өглөөний цай байхгүйд гайхшран үйлчлэгч эмэгтэйдээ:

-Өглөөний цай хаана байна? гэвэл эмэгтэй долоовор хуруугаа амандаа ойртуулж, Грегорын өрөө рүү зангав. Өнөө гурав гараа халаасандаа хийсэн чигтээ Грегорын өрөөнд орж цогцсыг нь олж харлаа.

Энэ үед ноён Замза эхнэр, охиныхоо хамт өрөөнөөсөө гарч ирээд:

-Та нар одоохон манайхаас яв! гэж хэлэхдээ нулимс унагасан нь илт. Өнөө гурвын нэг:

-Энэ чинь юу гэсэн үг вэ? гэхэд нөгөө хоёр нь сайхан хэрүүл хийх нь гэсэн шиг гараа ардаа үрж зогсов. Ноён Замза:

-Та гурвыг одоохон яв гэж байна гэхэд нөгөө эр шал ширтэн зогсоод:

-За за. Тэгвэл бид явъя даа гэсэн ч ноён Замзаг ширтсээр байлаа.

Энэ үед ноён Замза нүдээ бүлтийлгээд толгойгоо үг дуугүй хэд дохиход өнөөх эр үүд рүү алхаж, нөгөө хоёр нь хоцорчих вий гэсэн шиг хойноос нь харайлгав. Мань гурав үүдний өлгүүрт өлгөсөн малгай, таягнуудаа авч мэхийн ёслоод гарч одлоо. Ноён Замза эхнэр, охины хамт хонгилд гарч шатны бариул түшин харвал өнөө гурав шатаар аажуухан уруудна. Чингэхдээ эргэлтэн дээр хэсэг харагдахаа болиод дахин гарч ирэх ажээ. Махны мухлагийн түгээгч эр толгой дээрээ сагс тавин шатаар өгсөхөд Замзагийнхан гэртээ орлоо.

Замзагийнхан энэ өдөр амарч зугаалахаар шийдэж, ширээндээ суугаад гурвуул ажил олгогчиддоо зурвас бичигцгээв. Гурвуул урт удаан хугацаанд амс хийх чөлөөгүй ажилласан тул амрах шаардлагатай байлаа. Энэ хооронд үйлчлэгч эмэгтэй өглөөний ажлаа дуусгаад явж буйгаа дуулгахаар орж ирвэл гурвуул толгой дохисон ч эмэгтэй зогссоор л. Замзагийнхан өөрийн эрхгүй толгой өндийлгөв. Ноён Замзаг:

-Ямар нэгэн юм болоо юу? гэвэл эмэгтэй асууж лавлуулж байж хэлэх гэсэн аятайхан мэдээтэй боллоотой үүдэн дээр эргэлдэнэ. Үйлчлэгч эмэгтэйн малгайдаа хатгасан цацагт хяруулын өд нь дэрвэлзэх агаад хатагтай Замза:

-Та юм хэлэх гэсэн юм аа даа? гэвэл эмэгтэй инээвхийлэн:

-Тийм ээ. Нөгөө юмыг зайлуулах гэж санаа зовсны хэрэггүй шүү. Би аль хэдийнэ янзалчихсан гэв.

Хатагтай Замза, Грета хоёр зурвасаа үргэлжлүүлэн бичвэл ноён Замза үйлчлэгч эмэгтэйг юу хийснээ нэгд нэгэнгүй тоочихыг гараа занган хориглолоо. Эмэгтэй арга буюу “Баяртай” гэсээр хаалга саван гарав.

-Энэ эмэгтэйг орой ажлаас нь хална аа гэж ноён Замзаг өгүүлэхэд нөгөө хоёр юм хэлсэнгүй. Үйлчлэгч эмэгтэй дөнгөн данган мэдэрсэн тэр л амар амгалан байдлыг нь алдагдуулжээ. Хоёр эмэгтэй босч цонхон тушаа тэврэлдэн зогслоо. Ноён Замза тэдэн рүү эргэж хараад:

-Наашаа суугаад энэ бүхнийг мартацгаа даа. Намайг бага ч гэсэн бодооч хэмээв.

Хоёр эмэгтэй хажууд нь очоод төд удалгүй зурвасаа бичиж дуусгав. Ингээд тэд энэ хэдэн сарын хугацаанд анх удаа гурвуул гэрээсээ гарч, трамвайд суугаад хотын зах руу явлаа. Нар туссан трамвайд өөр улс байсангүй. Гурвуул тухтайхан суугаад ирээдүйнхээ талаар ярилцав. Урьд нь ажил төрлөө хэлэлцэж байгаагүй бөгөөд хэн хэнийх нь ажил ихээхэн боломжийн байж таарчээ. Грегорын сонгосон энэ байрнаас арай хямд, жижиг, тохь тухтай байр хөлсөлбөл амьдрал нилээд хөнгөрөх юм. Эцэг эх нь сүүлийн үед тэдэнд тохиосон хүнд нөхцөл байдлаас үл хамааран охин Грета нь сайхан бүсгүй болсныг гэнэтхэн анзаарлаа. Гурвуул дуугаа хураахад эхнэр нөхөр хоёр охиндоо сайн хань олох цаг нь ирж дээ хэмээн бодов. Зорьсон газартаа ирэхэд Грета аав, ээжийнхээ бодол санааг таасан бололтой залуу сайхан бие хаагаа гайхуулах шиг түрүүлж бослоо.

Table of Contents

[1](#)
[2](#)
[3](#)